

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ АУДИТОР**

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг  
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр  
Утас:26-04-37, Факс:51-26-42-30  
E-mail: info@audit.gov.mn

2024.04.25 № 1073

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

Дүгнэлт хүргүүлэх тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйл, Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.5, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5.4-т заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд 2024 оны Улсын Их Хурлын ээлжит сонгуульд оролцох "Ард түмний хүч нам"-ын сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянаж, дүгнэлт гаргалаа.

**Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл**

Улсын Их Хурлын сонгуульд оролцох нам, эвсэл нь сонгуулийн мөрийн хөтөлбөрөө Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, Монгол Улсын хөгжлийн урт хугацааны бодлого, Улсын Их Хурлаас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт нийцүүлэн боловсруулж, санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын тооцоо, судалгааг гаргаж, хуульд заасны дагуу хянуулан дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

**Дүгнэлтийн үндэслэл**

Үндэсний аудитын газар нь Улсын Их Хурлын сонгуульд оролцох нам, эвсэл болон бие даан нэр дэвшигчийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянан үзэхдээ Төрийн аудит MNS 6817:2020 стандарт, түүнийг хэрэгжүүлэх журам, заавар, аргачлалыг удирдлага болгон Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, УИХ-аас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны Төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны Төсвийн төсөөллийн тухай хуулийг тус тус шалгуур болгож дүгнэлт гаргалаа.

**Дүгнэлт**

Улсын Их Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцохоор "Ард түмний хүч нам"-ын ирүүлсэн сонгуулийн мөрийн хөтөлбөрт тусгасан зорилт, арга хэмжээ нь Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.5 дахь хэсэг, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3 дахь хэсэг, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлагад тус тус нийцсэн байна.

"Ард түмний хүч нам"-ын мөрийн хөтөлбөр /.....11..... хуудас/-ийг хавсаргав.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ  
АУДИТОРЫН АЛБАН ҮҮРГИЙГ  
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Д.ЗАГДЖАВ

Z:\Yawsan\_Bichigi\2024\0420 GNAG-3.Docx

0001030678

Ард Түмний Хүч Намын Бага Чуулганы  
2024 оны 03 дугаар сарын 21-ний өдрийн  
хуралдааны 03 дугаар тогтоолоор батлав



## АРД ТҮМНИЙ ХҮЧ НАМЫН 2024 ОНЫ УИХ-ЫН ЭЭЛЖИТ СОНГУУЛИЙН МӨРИЙН ХӨТӨЛБӨР

/ Монгол Улсын Их Хурлын Сонгуулийн тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.9 дэх заалт болон Үндэсний аудитын газрын дүгнэлт, зөвлөмжийг баримтлан 2024 оны 04 дүгээр сарын 09-ний өдрийн Намын Тэргүүлэгчдийн хуралдааны 03 дугаар тогтоолоор энэ хөтөлбөрийн 1.4, 1.7, 1.9, 1.10, 1.21, 3.14 дэх заалтуудыг өөрчлөн найруулж баталсан /


### УРИА: АРД ТҮМЭН ХҮЧТЭЙ!

Монголын ард түмэн-монгол хүн бүр бие эрүүл, ухаан саруул байж, хүсэл сонирхолдоо нийцсэн ажил хөдөлмөр эрхэлж, амьдралдаа хүрэлцэхүйц цалин-орлоготой, тохилог орон гэртэй, эрүүл, аюулгүй орчинд амар тайван амьдрах нөхцлийг бүрдүүлэх нь манай намын сонгуулийн мөрийн хөтөлбөрийн эрхэм зорилго мөн.

Монгол түмнийхээ агуу түүхт суут хүчийг алдраа болгосон манай нам 2024 оны УИХ-ын ээлжит сонгуульд нийгмийн хөгжлийн, эдийн засгийн хөгжлийн, шударга засаглал, аюулгүй байдлын, ногоон хөгжил, аюулгүй орчны бодлогын хүрээнд эрс өөрчлөлтийг агуулсан "АРД ТҮМЭН ХҮЧТЭЙ!" уриа бүхий дараах хөтөлбөрийг Ард түмэн-Сонгогч олондоо өргөн толилуулж байна.

### Нэг. Нийгмийн хөгжлийн бодлого

1.1. Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсрол эзэмшигчдэд эх газар нутаг, унаган байгалиа хайрлан хамгаалах, үндэсний түүх, хэл, соёл, өв уламжлал, ёс заншлаа хүндэтгэн дээдлэх, сурч мэдэх, бүтээлчээр хөгжүүлэхэд чиглэсэн боловсролыг түлхүү олгож, хүнлэг энэрэнгүй, эх оронч монгол хүн, монгол улсын иргэн болгож төлөвшүүлнэ..



1.2. Өмчийн хэвшил, төв, орон нутгийн харъяаллаас хамаарсан ерөнхий боловсролын түвшний ялгаа гаргахгүй байх, бага боловсрол эзэмшүүлэх эхний 2 жилд малчдын хүүхдийг гэрийн сургалтын хөтөлбөрт хамруулах бодлого хэрэгжүүлнэ.

1.3. Гурваас зургаан насны хүүхдийг цэцэрлэгт бүрэн хамруулах, 1-3 насны хүүхдийг яслид асран өсгөх нөхцлийг бүрдүүлэх чиглэлээр бодлогын шинэчлэл хийнэ.

1.4. Их, дээд сургуулийн хөтөлбөрийг чанаржуулах, нэгтгэх, цөөлөх чиглэлээр хянан магадлаж, тэдгээрийг УБ хотоос орон нутагт шилжин байршуулах хийгээд инженер, технологийн мэргэжлийн элсэгчдийг дэмжих бодлого баримтална.

/Энэ заалтыг 2024 оны 04 дүгээр сарын 09-ний өдрийн Намын Тэргүүлэгчдийн хуралдааны 03 дугаар тогтоолоор өөрчлөн найруулж баталсан/

00000001

1.5. Мэргэшсэн ажилтан бэлтгэх, тэднийг үйлдвэрлэлтэй холбоход чиглэсэн боловсролын тогтолцооны шинэчлэлт хийнэ.

1.6. Хүн бүрийг эрүүл мэндийн чанартай, хүртээмжтэй, чирэгдэлгүй, төлбөрийн дарамтгүй оношилгоо, эмчилгээ, үйлчилгээнд хамруулж, ард олноо өвчин эмгэгээс урьдчилан сэргийлэх, нийтийн биеийн тамирыг хэвшүүлэх, эмийн аюулгүй байдлыг хангаж, эмийн үнийн дарамтаас хамгаалах, эрүүлжүүлж илааршуулах явдлыг эрүүл мэндийн салбарын тэргүүн зорилт болгоно.

1.7. Өрхийн болон сумын эрүүл мэндийн төв, аймаг, дүүргийн нэгдсэн эмнэлэгүүдийг эмнэлэгийн орчин үеийн тоног төхөөрөмж, техник хэрэгслээр хангах, зайн оношлогоог нэвтрүүлэх, хүн бүрт эрүүл мэндийн үйлчилгээний дэвшилтэт ололтыг хямд хүртээж, эх орондоо найдвартай эмчлэгдэх нөхцлийг бүрдүүлэх бодлого баримтална.

*/Энэ заалтыг 2024 оны 04 дүгээр сарын 09-ний өдрийн Намын Тэргүүлэгчдийн хуралдааны 03 дугаар тогтоолоор өөрчлөн найруулж баталсан/*

1.8. Хүн ардад ажил, амьдралын эрүүл, аюулгүй орчин бүрдүүлж, агаар, хөрс, усны бохирдолтоос болж эрүүл мэндээр хохирогсдын шууд хохирлыг төрөөс нөхөн төлж, улмаар буруутай этгээдээр нөхөн төлбөрийг гаргуулах эрх зүйн орчин бүрдүүлнэ.

1.9. Эмнэлэг, боловсролын байгууллагын эмч, багш, ажиллагсад амьжиргаандаа бүрэн хүрэлцэхүйц цалин хөлс авч, сэтгэл хангалуун ажиллаж, амьдрах таатай орчин бүрдэх нь салбарын бодлогын шинэчлэлийн бодит үр дүнгийн салшгүй нэгэн хэсэг байна.

*/Энэ заалтыг 2024 оны 04 дүгээр сарын 09-ний өдрийн Намын Тэргүүлэгчдийн хуралдааны 03 дугаар тогтоолоор өөрчлөн найруулж баталсан/*

1.10. Хүн амаа өсгөх, хүний хөгжлийг хангах, хүнээ халамжлахад чиглэсэн бодлого болох "хүүхдийн мөнгө"-ийг анх санаачилсан намын даргынхаа санаачлагын агуулга хэлбэрийг төгөлдөржүүлэх, насны хишиг, одонтой ээжийн тэтгэмжийн нэр хүнд, өгөөжийг дээшлүүлэх хүрээнд эрх зүйн орчны шинэчлэлт хийнэ.

*/Энэ заалтыг 2024 оны 04 дүгээр сарын 09-ний өдрийн Намын Тэргүүлэгчдийн хуралдааны 03 дугаар тогтоолоор өөрчлөн найруулж баталсан/*

1.11. УБ хотоос орон нутаг руу шилжих хөдөлгөөнийг жинхэнэ утгаар нь өрнүүлж, хөдөлгөөнд нэгдэгсэдийг боломжтой бүх хэлбэрээр урамшуулж, төвлөрлийг сааруулах, орон нутгаа хөгжүүлэх, хөдөөгийн иргэдийнхээ амьжиргаа, нийгэм, соёлын эрэлт хэрэгцээг хамгаалах, хангах, хот, хөдөөд хөдөлмөр эрхлэн орлого олох адил нөхцлийг бүрдүүлнэ.

1.12. Төв, орон нутгийн хот суурингийн гэр хорооллыг боломжит шийдэл бүхий дулаан, цэвэр, бохирын шугамд холбох, био жорлон нэвтрүүлэх, шорон замыг хатуу хучилттай болгох, агаар дахь түлшний хор хөнөөлийг арилгах, коксжсон



00000002

түлшний үйлдвэрлэлийг дэмжих, ахуйн хог хаягдлын менежментийг шинэчлэх замаар хөрсний бохирдол, агаарын бохирдол, тоосжилтыг багасгаж, улмаар инженерийн байгууламж бүхий амины орон сууцны хороолол бий болох нөхцөлийг бүрдүүлнэ.

1.13. Хүн амын төвлөрөл бүхий хот, суурин газар бүрд усан хангамж, бохир ус цэвэрлэх байгууламжийн технологийн шинэчлэл хийх нь ард түмний амь нас, эрүүл мэндийн баталгааг хангах найдвартай үндэс гэж үзнэ.

1.14. Төв, орон нутгийн хот суурингийн хүн амын дийлэнхийг инженерийн шийдэл, тохилог эко орчин бүхий орон сууцаар хангаж, монгол хүний амьдралын чанарыг дээшлүүлнэ.

1.15. Химийн болон генийн өөрчлөлттэй хүнсний бүтээгдэхүүнийг илрүүлэх хүчин чадварыг бүрдүүлж, гаднаас оруулах, хэрэглэхийг хуулиар хориглоно.

1.16. Хүнсний аюулгүй байдлын стандартын шаардлага хангасан хүнсний бүтээгдэхүүний хэрэглээг дэмжиж, мөнхүү шаардлагад нийцсэн тээвэр, агуулахын сүлжээ, ложистик байгуулахыг дэмжинэ.

1.17. Монгол хүний хөдөлмөрийн үнэлэмжийг дээшлүүлэх, цагийн хөлсний хэлбэрийг жинхэнэ утгаар нэвтрүүлэх, дундаж орлоготой хэсгийг эрс нэмэгдүүлэх, орлого багатай хэсгийг тэтгэж дундаж орлоготны эгнээнд хүргэх бодлого хэрэгжүүлнэ.

1.18. Аливаа ажил, хөдөлмөрийг гэрээний харилцаанд заавал хамруулж, ажиллагсадыг цалин хөлс, хангамжаа нэмэгдүүлэх, ажлын байраа тогтвортой хадгалах, хөдөлмөрийн мөлжлөгт орохоос хамгаалах эрх зүйн орчныг бүрдүүлнэ.

1.19. Ард олны жижиг дунд бизнесийг жинхэнэ утгаар нь тэгш, шударгаар дэмжиж, энэ төрлийн зориулалттай тоног төхөөмжийн гаалийн татварыг хөнгөлөх, чөлөөлөх асуудлыг судлан хэрэгжүүлж, тогтвортой, баталгаатай ажлын байрыг мэдэгдэхүйц нэмэгдүүлнэ.

1.20. Дотоодын хязгаарлагдмал хэрэгцээ бүхий зах зээл дээр ижил төрлийн бизнесийг олноороо зэрэгцүүлэн эрхэлж бизнесээ жижигрүүлдэг, улмаар дампууруулдаг явдлаас хамгаалах эрх зүйн орчин бүрдүүлнэ.

1.21. Ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, амьжиргааны баталгаажих түвшингээс доогуур орлоготой иргэд зэрэг нийгмийн зорилтот бүлгийг дэмжих бодлогыг бүтээлчээр үргэлжлүүлж дэмжинэ.

*/Энэ заалтыг 2024 оны 04 дүгээр сарын 09-ний өдрийн Намын Тэргүүлэгчдийн хуралдааны 03 дугаар тогтоолоор өөрчлөн найруулж баталсан/*

1.22. Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тогтолцооны шинэчлэлийг төгөлдөржүүлж, нийгмийн даатгалын шимтгэлийн ачааллыг хөнгөлөх, эрүүл мэндийн даатгалын өгөөжийг нэмэгдүүлэхэд анхаарна.



00000003

1.23. Сүүлийн 30 гаруй жилийн төрийн бодлогод чамлалттай байр суурь эзэлж ирсэн шинжлэх ухааны салбарын ач холбогдлыг онцгойлон үзэж тууштай дэмжинэ.

1.24. Ард түмэнд амьдрах орон гэрээ барих, бизнес эрхлэх зориулалтаар газрыг жинхэнэ утгаар нь тэгш, шударгаар өмчлүүлэх, эзэмшүүлэх, үр ашгийг нь түргэн хүртэх газрын шинэтгэл, дахин хуваарилалтын бодлого хэрэгжүүлнэ.

## Хоёр. Эдийн засгийн хөгжлийн бодлого.

2.1. Төсвийн хөрөнгө оруулалтыг үнэлэх, эрэмбэлэх, сонгох шалгуур үзүүлэлтийн аргачлалыг төгөлдөржүүлэн үр ашиг муутай барилга, байгууламж, хөшөө суварга барихад зарцуулж буй одоогийн хөрөнгө оруулалтын санхүүжилтийн тогтолцоог эрс өөрчилж, төрийн захиргааны албаны нүсэр зардлыг эрс багасгах замаар дотоодын нийт бүтээгдэхүүнд төсвийн зардлын эзлэх хувийг мэдэгдэхүйц бууруулна.

2.2. Батлагдсан улсын төсвийг зардал нэмэх зорилгоор ойр ойрхон өөрчилж, түүндээ нийцүүлэн улс орны өрийн таазын хэмжээг өсгөсөөр ирсэн увайгүй явдлыг таслан зогсоож, төсвийн орлого, зарлагын төлөвлөлтийн бодит үндэслэлийг сайжруулж, төсвийг алдагдалгүй баталдаг хууль эрх зүйн орчин бүрдүүлнэ.

2.3. Хүн ардын эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгаалалд түлхүү чиглэсэн төсвийн бодлого хэрэгжүүлнэ.

2.4. Татварын бодлогын эрх зүйн шинэчлэлийг төгөлдөржүүлж, нэмэгдсэн өртгийн албан татварын дарамтыг хөнгөлөх, өнгөрсөн 8 жилд шинээр бий болгосон, хувь хэмжээг нь нэмэгдүүлсэн татвар, хураамжийг буцааж байранд нь тавих, дундаас доош орлоготой иргэдийг орлогын албан татвараас чөлөөлөх, хэт өндөр орлоготой иргэдийн татварыг нэмэгдүүлэх бодлогын шинэчлэл явуулна.

2.5. Эх орон, газар нутгаа ухаж төнхөн баялагаа түүхийгээр нь гадагш уралдан зөөвөрлөдөг гаж бодлогыг халж, түүхий эдийг дотооддоо боловсруулж, нэмүү өртөг шингэсэн эцсийн бүтээгдэхүүн гаргах, байгальд ээлтэй, өрсөлдөх чадвартай үйлдвэржилтийг дэмжинэ.

2.6. Стратегийн чанартай уул уурхай, хүнд үйлдвэрийн томоохон төсөл, үйлдвэрлэлийн цогцолборуудыг зөвхөн монголын ард түмнийхээ эрх ашигт захируулан ашиглах, барьж байгуулах замаар эдийн засгаа тэлнэ.

2.7. Төрийн болон хувийн өмчийн монополь компаниудын дүрмийн сангийн гуравны нэг хүртэлх хувийг иргэдэд шилжүүлэх замаар өмч хөрөнгө, үйл ажиллагааг нь ард түмний хяналтад оруулах, өмч хөрөнгийн хэт төвлөрлийг задлах, нийгэмд өмч, орлогын тэгш байдал бүрдүүлэх бодлогын шинэчлэл хийнэ.



00000004

2.8. Өнгөрсөн хугацаанд төрийн өмчит хуулийн этгээдийг үнэгүйдүүлэн зальт аргаар хувьчилж авсан, менежментийн хувьчлал нэрийн дор үнэгүй эзэмшиж буй шударга бус үйлдлийг илрүүлж, хувьчлахаар гаргасан шийдвэрийг хүчингүй болгох эрх зүйн орчин бүрдүүлнэ.

2.9. Төрийн албан тушаалын эрх мэдэл, төрийн хязгаарлагдмал мэдээллийг олзлон бизнесийн монополь тогтоодог явдлыг таслан зогсоож, эрх тэгш оролцоог хангасан бизнесийн хуваарилалтын бодлогын шинэчлэл хийнэ.

2.10. Эрчим хүч, агаарын, төмөр замын болон нийтийн тээвэр, харилцаа холбоо зэрэг стратегийн томоохон төрийн өмчит аж ахуйн нэгжүүдийн статусыг хэвээр хадгалж, хүчин чадал, хүн амд үзүүлэх үйлчилгээний соёл, чанар, хүртээмжийг дээшлүүлэх, үнэ тарифын уян хатан нөхцлийг бүрдүүлэх бодлого хэрэгжүүлнэ.

2.11. Согтууруулах, мансууруулах бүтээгдэхүүн, эм, бензин зэрэг онцгой төрлийн бүтээгдэхүүний импорт, үйлдвэрлэлийг төрийн онцгой хяналтад авна.

2.12. Эрдэс баялагийн тусгай зөвшөөрөл авч, түүнийгээ бусдад худалдаж олсон орлогод татвар ногдуулах, өмнө нь эрх мэдэл, арга заль, луйвараар зөвшөөрөл авч олсон орлогод ногдох татварыг нөхөн төлүүлэх эрх зүйн орчин бүрдүүлнэ.

2.13. Ард түмний татварын хөрөнгөөр нөөцийг нь тогтоосон ашигт малтмалын ордуудыг шууд төрийн мэдэлд авах эрх зүйн орчин бүрдүүлж, байгальд ээлтэй дэвшилтэт технологийн дагуу олборлолт явуулж үр өгөөжийг нь монгол хүн нэн тэргүүнд хүртэх бодлого хэрэгжүүлнэ.

2.14. Барилга, барилгын материалын үйлдвэрлэлийн хөгжлийн хүрсэн түвшинг ахиулж, салбарын ажиллагсадын хөдөлмөрийн нөхцөл, аюулгүй байдал, цалин хөлс, нийгмийн баталгааг хангаж хамгаалах бодлого хэрэгжүүлнэ.

2.15. Нефть бүтээгдэхүүний импорт, бөөний худалдааг төрийн мэдэлд авч, цахилгаан, дулаан, нефть бүтээгдэхүүний үнийг улс даяар нэг төвшинд байлгах бодлогын шинэчлэл хийнэ.

2.16. Газрын тосны олборлолтыг нэмэгдүүлэх, экспортыг хориглох, тос боловсруулах үйлдвэрээ ашиглалтанд оруулах, нүүрснээс хий, шингэн түлш гарган энэ төрлийн бүтээгдэхүүний гадаад хамаарлаас ангижрах бодлого хэрэгжүүлнэ.

2.17. Дотоодынхоо эрчим хүчний найдвартай хангамж, аюулгүй байдлыг хангах стратегийн зорилго тавьж нэн тэргүүнд эхлүүлсэн төслүүд болон Улаанбаатарын 5 дугаар дулааны цахилгаан станц, Тавантолгойн болон Багануурын дулааны цахилгаан станцууд, бүс нутгийг холбосон цахилгаан дамжуулах агаарын шугамуудыг барьж байгуулахыг дэмжинэ.

2.18. Агаарын, төмөр замын, авто замын талаархи төрийн бодлогын улс төрийн шийдлийг хадгалан үргэлжлүүлж, хот сууринд нийтийн тээврийн орчин үеийн нэвтрүүлэх, сумдыг авто замын сүлжээнд холбох бодлого хэрэгжүүлнэ.



00000005

2.19. Өнгөрсөн хугацаанд гадаадын хөрөнгө оруулагчтай хийсэн гэрээ хэлцлийг монгол орон, монголын ард түмний язгуур эрх ашигтай уялдуулан засаж сайжруулах, илт эх орон, ард түмний эрх ашигт харшилсаныг нь хүчингүй болгох чиглэлээр бодлогын шинэчлэлт явуулах эрх зүйн орчин бүрдүүлнэ.

2.20. Малын халдварт, гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх тарилга, үйлчилгээний санхүүжилтийг бодит гүйцэтгэлээр олгож, малын эрүүлжүүлэлтийг олон улсын стандартад хүргэнэ.

2.21. Мал, малын гаралтай бүтээгдэхүүнийг шууд малчдын гараас худалдан авч, мах, ноос, ноолуур, арьс шир, сүү, тос боловсруулах стандарт хангасан үйлдвэр, мах нөөцлөх зориулалт бүхий агуулах байгуулах, дотоодын мах нийлүүлэлтийн тогтолцоог шинэчлэх, хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний биржийн худалдааг жинхэнэ утгаар нь хөгжүүлэх цогц бодлого хэрэгжүүлнэ.

2.22. Мал аж ахуйн гаралтай түүхий эдийг дотоод, гадаадын худалдаачдын зохион байгуулалт бүхий үнийн огцом унагалт, халдлагаас сэргийлэхэд чиглэсэн бодлого явуулна.


2.23. Мал аж ахуйн таваарлаг чанарыг дээшлүүлэх, мал аж ахуйн гаралтай бүтээгдэхүүний экспортыг нэмэгдүүлэх, мал сүргийн зохистой бүтцийг бий болгож, генийн санг хамгаалах, ган, зудын эрсдлийн сан байгуулах, өвс тэжээлийн аюулгүйн нөөц бүрдүүлэх, даатгалын тогтолцоог шинэчлэх, таримал тэжээлийн үйлдвэрлэлийг бодитой дэмжих, бэлчээр хамгаалах цогц бодлого хэрэгжүүлнэ.

2.24. Экспортод чиглэсэн өндөр ашиг шимтэй эрчимжсэн мал аж ахуйг газар тариалантай хослуулан хөгжүүлнэ.

2.25. Тариалангийн даатгалын тогтолцоог бүрдүүлэх, улаанбуудай, хүнсний ногооны импортын хэрэглээг хязгаарлах, тариалалт, хураалтыг улам бүр механикжуулах, автоматжуулах, агуулахын аж ахуй, усалгаатай газар тариаланг хөгжүүлэх, үр тарианы талбайг хашаалж хамгаалах замаар дотоодын хэрэглэгчдийн болон үрийн нөөцийн хэрэгцээг бүрэн хангаж улмаар экспортын боломжийг бүрдүүлэх бодлого баримтлана.

2.26. Гурил, гурилан бүтээгдэхүүний үнийн бодит бус өсөлтийг таслан зогсоож, хүн амын хүнсний гол нэр төрлийн бүтээгдэхүүний /мах, гурил, цагаан будаа, төмс зэрэг/ үнийг төрөөс зохицуулах эрх зүйн орчин бүрдүүлж, иргэдээ үнийн дарамтаас хамгаална.

2.27. Банкуудын өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх, монополь байдлыг халах, хувь эзэмшлийг задлах талаархи хуулийн хэрэгжилтийг түргэтгэх, хүү багатай зээл олгох, монгол хүний эрх ашигт нийцсэн хүү багатай гадаад эх үүсвэрийг татах зээлийн хүүгийн дээд хязгаарыг төрөөс хянаж, зохицуулах бодлого хэрэгжүүлнэ.



00000006

2.28. Гадаадын хөрөнгө оруулалттай бүх аж ахуйн нэгжүүд экспортын орлогоо монгол улсын банкаар дамжуулан гүйцэтгэж, санхүүгийн тайлан тэнцлээ монгол хэлээр, монгол төгрөгөөр гаргадаг байх эрх зүйн орчин бүрдүүлж хатуу мөрдүүлнэ.

2.29. Төр, хувийн хэвшлийн одоо ашиглаж байгаа болон ирээдүйд ашиглах ашигт малтмалын ордын орлого, нөөц ашигласны төлбөрөөс үндэсний баялгийн санг бүрдүүлж, сангийн орлогоос ард түмэн тэгш, шударга хүртэх эрх зүйн орчин бүрдүүлнэ.

### Гурав. Шударга засаглал, аюулгүй байдлын бодлого.

3.1. Ард түмнээ дээдлэх төрт ёсны уламжлал, шударга ёс, тэгш байдлыг тогтоох, хууль ёс дэг журмыг хангах, төрийн албаны сахилгыг эрс чангатгахад чиглэсэн улс төр, эрх зүйн бодлого хэрэгжүүлнэ.

3.2. Аливаа хууль, тогтоомж нь төр, байгууллага, албан тушаалтны эрх ашгийг хамгаалсаар ирсэн тэгш бус бодлогыг халж, хуулийг зөвхөн хүний сайн сайхны төлөө, хүнийг хамгаалахын төлөө батлан гаргана.

3.3. Намын болоод амин хувийн зорилгоос ангид байж чадах өндөр мэдлэг, ур чадвар бүхий эх орон, ард түмний язгуур эрх ашгийг эрхэмлэгч, ноён нуруутай, хүнлэг, ёс зүйтэй иргэдээр бүх шатны төрийн албыг бэхжүүлнэ.

3.4. Төрийн алба нь ард түмэнд ил тод, алагчлалгүй, шударга, хүртээмжтэй, хүнд сурталгүй үйлчилдэг, цомхон, мэргэшсэн, хариуцлагатай байх чиглэлээр эрс шинэчлэл хийнэ.

3.5. Үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийн тоог дахин хумиж, бүртгэлийн тогтолцоонд шилжүүлэх ажлыг төгөлдөржүүлж, энэ талаархи төрийн хүнд суртал, авилгыг таслан зогсооно.

3.6. Төрийн албаныханы төсвийн мөнгөөр тансаг оффис барьдаг, түрээсэлдэг, төрөл бүрийн өндөр үнэ хөлстэй үйлчилгээ авдаг, тансаг, хурд хүчтэй уналга хөсөг хэрэглэдэг байдлыг халж, удирдах албан тушаалтны тоог эрс цөөлөх бодлого явуулна.

3.7. Аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ, Засаг даргын сонгуульд зөвхөн намууд нэр дэвшүүлдэг одоогийн тогтолцоог өөрчилж, иргэний нийгмийн байгууллага, нутаг орны иргэд санал нэгдэн нэр дэвшүүлэх, аймаг, дүүрэг, нийслэл, сумын Засаг даргыг ард иргэдийн шууд саналаар сонгох, баг, хорооны засаг даргыг дээд шатны засаг дарга томилдог байх эрхийг хуульчилна.

3.8. Сонгогчдын саналаар УИХ-ын гишүүнийг эгүүлэн татах, Засаг даргыг огцруулах эрх зүйн тогтолцоог бүрдүүлнэ.

3.9. Хүннү төрөөс эхлэн үүсэж бэхжин хорь дугаар зуунтай золгосон монгол төрийн засаглалын уламжлалыг парламентын засаглалтай нийцүүлэн хадгалж



00000007



газраа Ерөнхийлөгч нь тэргүүлдэг засаглалын хуваарилалт бүхий Үндсэн хуулийн өөрчлөлтийг дэмжинэ.

3.10. Хараат бус мөрдөн шалгах тогтолцоог төгөлдөржүүлэх хүрээнд төрийн өндөр дээд албан тушаалтнуудын үйлдсэн гэмт хэргийг шалгах Мөрдөн шалгах комиссыг УИХ-н дэргэд, хуулийн байгууллагын албан тушаалтнуудын үйлдсэн гэмт хэргийг Мөрдөн шалгах нэгжийг Улсын Ерөнхий Прокурорын дэргэд тус тус байгуулж, хууль, шүүхийн өмнө иргэд эрх тэгш байх Үндсэн хуулийн зарчмыг хатуу сахиулна.

3.11. Улс орон, ард түмнийг өр зээлийн барьцаанд оруулсан, улсын эдийн засаг, санхүүгийн нөөцийг шавхан хоосолсон, эх орон, ард түмний язгуур эрх ашигт хохирол учруулсан, сонгуулийн мөрийн хөтөлбөрөө үл биелүүлж, сонгогчдыг залилсан улс төрийн нам, бүлэглэл, улс төрчдөд хуулийн хариуцлага заавал хүлээлгэдэг эрх зүйн орчин бүрдүүлнэ.

3.12. Засгийн газар, нутгийн өөрөө удирдах байгууллагын төсөв, мөнгө, хүний нөөц, эд хөрөнгийн зохистой эрх мэдлийн тэнцлийг хангасан эрх зүйн орчны шинэчлэл хийнэ.

3.13. Засгийн газрын гишүүд болон төв, орон нутгийн төр, захиргааны байгууллагын удирдах албан тушаалд нэр дэвшүүлэх, томилгоо хийхэд заавал нам бусчуудын оролцоог харгалзан үздэг байх бодлогын шинэчлэл хийнэ.

3.14. 2019 оны нэмэлт өөрчлөлтөөр Монгол Улсын Үндсэн Хуульд оруулсан "Намыг Монгол Улсын сонгуулийн эрх бүхий иргэдийн нэг хувиас доошгүй тооны иргэн эвлэлдэн нэгдэж байгуулна" гэсэн заалтыг мөн хууль дахь нийгмийн болон өөрсдийн ашиг сонирхол, үзэл бодлын үүднээс нам байгуулах, сайн дураараа эвлэлдэн нэгдэх эрхтэй нийцүүлж хүчингүй болгох болон Улс төрийн намын тухай хуульд намын гишүүнчлэлийн уян хатан байдлыг хангах, намын дэмжигчдийн хүрээг тэлэх талаарх эрх зүйн шинэчлэлийг дэмжинэ.

*/Энэ заалтыг 2024 оны 04 дүгээр сарын 09-ний өдрийн Намын Тэргүүлэгчдийн хуралдааны 03 дугаар тогтоолоор өөрчлөн найруулж баталсан/*

3.15. Төрийн бус байгууллагын үйл ажиллагааны болон санхүүжилт, зардлын ил тод байдал, үүрэг, хариуцлагын тогтолцоонд шинэчлэл хийсэн хууль эрх зүйн орчныг бүрдүүлнэ.

3.16. Авилга, албан тушаалын гэмт хэрэгт ял шийтгүүлэгчийг бүх насаар нь нийтийн албанаас зайлуулж, хөрөнгийг нь хурааж, хорих ялын доод хэмжээг нэмэгдүүлж, ялыг хаалтай хорих ангид эдлүүлэхээр хуульд нэмэлт өөрчлөлт оруулна.

3.17. Өөрсдийн эрх ашигтаа нийцүүлэн хууль, тогтоомж баталдаг, засдаг явдлыг таслан зогсоох, энэ төрлийн үйлдэл, эс үйлдэл гаргагчдыг хуулийн хариуцлагад татах эрх зүйн орчин бий болгоно.



00000008

3.18. Улс төрийн нөлөөнөөс жинхэнэ утгаар ангид, хүний эрхийг дээдэлсэн, ял завшуулдаггүй, хуулийг ягштал дагаж мөрддөг чин шударга шүүх эрх мэдлийг төлөвшүүлэн бүрдүүлэх эрх зүйн шинэтгэлийн бодлогыг тууштай үргэлжлүүлэн төгөлдөржүүлнэ.

3.19. Энхийг эрхэмлэсэн, нээлттэй, бие даасан, олон тулгуурт гадаад бодлогын нэгдмэл байдал, залгамж чанарыг хадгалж, ОХУ, БНХАУ-тай стратегийн түншлэлийн харилцаагаа бататган, сайн хөршийн найрсаг харилцааг улам бүр төгөлдөржүүлэн хөгжүүлнэ.

#### **Дөрөв. Ногоон хөгжил, аюулгүй орчны бодлого.**

4.1. Цэвэр онгон байгалиа хойч үедээ өвлүүлэн үлдээх, улсын тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээг өргөжүүлэх, ард олон газар нутгаа зохистойгоор эзэмшиж, үр шимийг нь шударгаар хүртэх бодлого баримтлана.

4.2. Ойг түймэр, хөнөөлт шавьж, өвчин, хууль бус мод бэлтгэлээс хамгаалах, нөхөн сэргээх, мод орлох технологийг нэвтрүүлэх чиглэлээр бодлогын шинэчлэл хийнэ.

4.3. Ард түмний эрүүл мэнд байгаль орчин, мал амьтанд сөрөг нөлөө үзүүлэх цацраг идэвхит болон химийн хорт бодисын хэрэглээг багасгах, хязгаарлах, хор хөнөөл ихтэй уурхай, үйлдвэрийг эдийн засгийн үр ашгийг харахгүйгээр шууд хаах бодлого баримтлана.

4.4. Ард түмнийхээ эрүүл, аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг хангах зорилгоор уул уурхай, бусад байгалийн баялагийн нөхөн сэргээлт хийгээгүй иргэн, аж ахуйн нэгжид ногдуулах хариуцлага, эрүүгийн ял шийтгэлийг эрс чангатгах, байгаль орчинд хохирол учруулсан талаархи бодитой мэдээлэлийг урамшуулах, хүний үйл ажиллагаанаас үүдэлтэй байгаль орчны бохирдол, доройтлыг хязгаарлан зогсоох чиглэлд эрх зүйн орчны шинэчлэл хийнэ.

4.5. Ашигт малтмалыг хайх, олборлох, газар, бэлчээрийг эзэмших, өмчлөх эрх гагцхүү монголын ард түмний бүрэн мэдэлд байж, газрын хэвлийн баялгийг зөвхөн Монгол хүний язгуур ашигт нийцүүлэн гадны байгууллага, иргэд ашиглах эрх зүйн орчны шинэчлэл хийнэ.

4.6. Цөлжилтийг зогсоох, бэлчээрийн хэт талхагдлыг бууруулах, устах аюулд орж байгаа амьтан, ургамлаа хамгаалах ажлыг ард иргэдийнхээ санаачлага, дэлхийн хамтын нийгэмлэгийн дэмжлэгт тулгуурлан хийнэ.

4.7. Усны нөөцийн ашиглалтын нэгдсэн тогтолцоог бүрдүүлж, үйлдвэрлэл болон ахуйн хэрэгцээнд гадаргын усны нөөц, илүүдэл ус (Цас, борооны шар ус)-ыг ашиглах, хот, суурин газрын болон уул уурхайн үйлдвэрлэлийн бохир усны цэвэршүүлэх, эргүүлэн ашиглах зорилт тавьж, боловсруулах үйлвэрийн усны хэрэгцээг хязгаарлах, уул уурхайн үйлдвэрлэлд газрын гүний ус ашиглахыг



зогсоох, цэнгэг усны нөөц, гол мөрний урсац бүрэлдэх эхийн ихэнхийг улсын тусгай хамгаалалтад авах чиглэлээр бодлогын шинэчлэл явуулна.

4.8. Гадаргын усны нөөцийг усан сан, хиимэл нуур, хөв цөөрөм, байгуулах замаар хуримтлуулж, ус чийг дутагдалтай бүс нутгийнхаа хэрэгцээг хангах бодлого хэрэгжүүлнэ.

4.9. Монгол Улсын нутаг дэвсгэр дээр цөмийн болон цацраг идэвхит хаягдал хадгалах, булшлах, дамжуулан тээвэрлэх, энэ талаархи олон улсын конвенцид нэгдэх, аливаа хортой түүхийг ~~эд, бараа бүтээгдэхүүн~~ /автомашинны батерей зэрэг/ импортлох зэргийг хатуу хориглож, аюултай болон барилгын хог хаягдлыг устгах, байршуулах зориулалтын байгууламж, цэг бий болгох, дахин боловсруулах үйлдвэр байгуулах чиглэлээр дорвитой шинэчлэл хийнэ.

МӨНХ ТЭНГЭРИЙН ХҮЧИН ДОР  
МОНГОЛ ТҮМЭН МАНДАН БАЦРА

